

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

|    |  |         |
|----|--|---------|
|    | <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>   | 1       |
|    | <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>  | 2 – 3   |
|    | <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>   | 4 – 26  |
| 1. | <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i> | 5 – 14  |
| 2. | <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i> | 14 – 26 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 3 дугаар сарын 20-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.*

*Томилолттой: Ж.Баярмаа, Б.Бейсен, М.Ганхүлэг, М.Нарантуяа-Нара;  
Чөлөөтэй: Ц.Баатархүү;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, М.Сарнай, Б.Түвшин, Ж.Чинбүрэн.*

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал, мөн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга М.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, С.Эрдэнэбат, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал хариулж, тайлбар хийв.

**Л.Энхнасан:** “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа, С.Эрдэнэбат нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал, мөн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга М.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал хариулж, тайлбар хийв.

**Л.Энхнасан:** “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 05 минут үргэлжилж, 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим  
10 цаг 25 минут

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энхнасан:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн хаврын чуулгын анхны хуралдааны мэндийг дэвшүүлье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэж ирсэн болон ирээгүй гишүүдийг сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа гишүүн 4 дүгээр тойрог, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн 10 дугаар тойрог, Хөххүүгийн Болормаа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Сархадын Зулпхар гишүүн 6 дугаар тойрог, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, 8 дугаар тойрог Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн одоо орж ирж байгаа.

Мөн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд ирээгүй гишүүн бол Жадамбаагийн Баясгалан гишүүн өвчтэй байгаа, Мягмардашийн Сарнай гишүүн өвчтэй байгаа, 2 дугаар тойрог Банзрагчийн Түвшин гишүүн өвчтэй, 8 дугаар тойрог, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн өвчтэй байна.

Гадаад томилолтоор Жудагийн Баярмаа гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн гадаад томилолттой байна.

Мөн 3 дугаар тойргийн Буланы Бейсен гишүүн орон нутагт томилолттой, 6 дугаар тойргийн Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн орон нутагт томилолттой байна.

Хурал тасалсан гишүүн 10 дугаар тойргийн Цэндийн Баатархүү гишүүн байна.

Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгд мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооноор хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Байнгын хорооны тогтоол батлах тухай. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай.

Хоёрдугаарт, Байнгын хорооны тогтоол батлах тухай. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсголын даргалагчийг томилох тухай эдгээр хоёр асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

---

### **Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл**

/Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

---

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүдийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийг сонсгол хийж 5 жилийн хугацаагаар томилно гэж заасан байгаа.

Энэ хүрээнд 2023 онд Улсын Их Хурлаас томилсон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн С.Эрдэнэбат нь Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон. Чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн байгаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай 14.2-ын штрих 2.2-т даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан Монголын Үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэж заасны дагуу Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Б.Рагчаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж Байнгын хороонд ирүүлсэн байна.

Нэр дэвшигчийн мэдээлэл, хуулийн лавлагааг Та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130.1-д нэр дэвшигчийн сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан бол Байнгын хороо энэ хуулийн 129.1-д заасан саналыг Улсын Их Хурлын чуулганы завсарлагааны хугацаанд ирсэн тохиолдолд ээлжит чуулган эхэлсэн өдрөөс

---

хойш ажлын 5 хоногийн дотор сонсголын товыг тогтоож, сонсголын даргалагчийг томилох ёстой.

Та бүхэн тогтоолын төслийг тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасны дагуу бид сонсголынхоо товыг тогтоосноос хойш 14 хоногоос доошгүй хоногийн хугацаанд сонсголын бэлтгэлийг хангах үүрэгтэй.

Иймд 14-өөс доошгүй өдрийн дотор сонсголд оролцогчдыг бүртгэх, нэр дэвшигчдээс асуулт асуух, саналыг бичгээр урьдчилан авах ажиллагааг явуулах учраас энэ өдрөөс хойш 14 хоногийн хугацааг тоолбол хамгийн боломжтой хугацаа нь 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр болж таарч байна. Энэ Даваа гарагт таарч байгаа.

Дэгийн хуулийн 120.8 дугаар заалтын дагуу сонсголыг Байнгын хороо болон чуулганы хуралдаантай өдөр давхардуулахгүй байх ёстой. Тийм болохоор 2025 оны 4 сарын 07-ны өдөр тогтож байна.

Өнөөдөр бид зөвхөн нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох. Тэгээд Байнгын хорооны энэ тогтоолыг хэлэлцэж батлах юм.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулна уу. Х.Буянжаргал Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, М.Нямдаваа Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга.

Ажлын хэсгийг танилцууллаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү?

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Х.Булгантуяа гишүүнээр тасаллаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асуугаад саналаа хэлнэ үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Одоо чинь зөвхөн тогтоолын төсөлтэй холбоотой л асуудал ярих уу?

**Л.Энхнасан:** Тийм.

**Б.Бат-Эрдэнэ:** Яах вэ, ер нь ингэмээр л байгаа. Би бас өнгөрсөн намрын чуулган дээр хэлж байсан. Энэ төрийн бус байгууллагуудаас Үндэсний зөвлөлд

нэр дэвшиж орж ирж байгаа хүмүүсийн асуудал. Тэгээд Үндэсний зөвлөлийнх нь өөрийнх нь мэдээж чиг үүрэг тодорхой бий.

Одоо жишээлбэл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээнд хийсэн Улсын Их Хурлын сонссон танилцуулга дээр үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд суурилсан дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт хангалтгүй, батлагдсан аргачлалыг бүрэн дагаагүй, байгууллагын ололт, давуу тал, сул тал, боломж, аюул заналыг тодорхойлох свот шинжилгээ хийгээгүй, тулгарч байгаа асуудлуудыг тодорхойлоогүй, хэрэгжээгүй болон хангалтгүй хэрэгжсэн арга хэмжээнүүдийн талаар тайлагнаагүй, зөвхөн ололттой талуудыг онцолсон гэдэг ч юм уу. Ингээд маш олон алдаа дутагдлууд гараад байгаа.

Тэгээд өнөөдөр Нийгмийн даатгалын сан маань өөрөө ямар байдалтай байгаа билээ.

Үндэсний зөвлөл дээр тодорхой байгууллагуудаас төлөөлөл орж ирээд сонгогдоод 5, 6 жилээр суугаад байдаг. Гэтэл нөгөө Нийгмийн даатгалын сан нь өөрөө ямар түвшинд байгаа билээ гэдгээ бид нэлээн сайн бодох ёстой. Энэ дээр тодорхой хэмжээний дүгнэлтүүд хийх ёстой болов уу гэж харж байгаа.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн эрх, үүрэг дотор ч гэсэн тодорхой хэмжээнд эрх үүргүүдийг нь заагаад өгчихсөн байдаг. Ялангуяа одоо жишээлбэл энэ свот шинжилгээтэй холбоотой асуудал дээр ер нь энэ нийгмийн даатгал, энэ байгууллагын үйл ажиллагаа ямар хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж яваагүйгээс улбаатай асуудлууд үүсэж байгаа гэж харж байгаа.

Нийгмийн даатгалын үйл ажиллагаа ч гэсэн доголдсонтой холбоотой асуудлууд байна.

Энэ дээр тодорхой хэмжээний алдаа дутагдлууд байгаа учраас, хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээнүүд хийгдэхгүй байгаа учраас, магадгүй хийгдсэн нь зөв хийгдэж чадахгүй байгаа учраас энд асуудал байгаа болов уу л гэж хараад байна л даа.

Тэгээд нэр дэвшигчийг тодорхойлох, нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох асуудлууд орж ирээд л байна. Бид нар энэ яг энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй холбоотой асуудлуудаа ер нь зүгээр энэ боломж байвал нэг удаа яг точный бүр цаг гаргаж байгаад сонсоод, яриад тухайн холбогдох асуудлуудыг гаргаж ирээд, яагаад өнгөрсөн хугацаанд алдаа дутагдал гарсан бол тэрийг өнөөдрийг хүртэл шийдвэрлэхгүй байгаа юм. Яагаад залруулахгүй байгаа юм. Яагаад энэ үндэсний зөвлөлд ажиллаж байгаа сонгогдсон нэр дэвшиж байгаа, магадгүй ороод ажиллаж байгаа Үндэсний зөвлөлийн гишүүд нь хариуцлага хүлээдэггүй юм гэдэг энэ холбоо бүхий асуудлуудыг ч гэсэн нэг удаа хөндөж ярих нь зөв болов уу гэж бодож байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Энэ тус тусдаа. Хамгийн эхлээд Эрүүл мэндийн даатгалынх шүү дээ. Тийм. Тус тусдаа явж байгаа. Нийгмийн даатгал нь дараа нь.

Тэгэхээр тогтоолтой холбоотой зөвхөн хурлын сонсголын тов зарлах. Тэгээд даргалагчаа сонгох юм. Тийм.

Тэгэхээр та дараагийн хоёрдугаар асуудал ярихад ярьж болох нь. Бид удахгүй тайлан сонсоно. Тийм. Тэгэхээр тайлангийн үед илүү дэлгэрэнгүй ярих боломжтой.

Ц.Идэрбат гишүүн асуултаа асууж, саналаа хэлнэ үү.

**Ц.Идэрбат:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад ярихын тулд би Үйлдвэрчний эвлэлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал даргаас зарим нэг зүйлийг тодруулъя.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг сонгох процесст хуулиараа Үйлдвэрчний эвлэл даатгуулагчийг төлөөлж 3 хүнийг явуулдаг. Нэрийг нь дэвшүүлдэг. Тэгээд өнгөрсөн 2 жилийн өмнөх болсон сонгуулиар би сонгол даргалагчийн хувьд яг л энэ асуудлыг ярьж байсан байгаа юм.

Үйлдвэрчний эвлэл хуулиар олгогдсон эрхээ биелүүлэхийн тулд ямар процессын үйл ажиллагаа явуулсан бэ? Энэ яг даатгуулагчийг төлөөлж байгаа энэ төлөөллийн эрхийг хангах энэ хүмүүсийг сонгохдоо танай үйлдвэрчний эвлэлийн өөрийн дотоод дүрэм, журам хуульд заагдсан янз янзын процесс байдаг уу? Тэр дагуу хийгдсэн үү, үгүй юу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яахаараа дандаа Үйлдвэрчний эвлэлийн дарга нар нь дандаа Үндэсний зөвлөлүүд рүү орно гэж орж ирээд байдаг юм бэ? Та нарт өөр хийх ажил зөндөө баймаар юм.

Би 2 жилийн өмнө хэлж л байсан. Үйлдвэрчний эвлэл өөрөө ямар том байгууллага билээ. Зөндөө л ажил байгаа. Та нарт. Тэгээд дарга нар нь Үндэсний зөвлөл рүү орж ирээд. Тэгээд процесс нь яваад энэ даргыгаа бүгдээрээ танайх ямар процессоор явуулаад яаж дэмжсэн юм бэ гэхээр бид хоорондоо ярьж байгаад шийдчихсэн юм гэдэг нэг бөөрөнхий юм хэлээд. Тэгээд дараа дараагийн удаа Та бүхэн битгий ингээрэй гэсэн. Тэгээд өнөөдөр дахиад та нар дэд ерөнхийлөгчөө оруулаад ирж байна. Би хүн яриагүй. Зүгээр албан тушаалыг нь ярьж байгаа. Тийм.

Тэгэхээр салбарын үйлдвэрчний эвлэлүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Тэгээд энэ үед одоо тэгээд энэ чинь даатгуулагчийг төлөөлж байгаа

энэ процессыг сонгохдоо яаж явуулсан юм? Яагаад дандаа дарга нар нь ээлжилж орж ирээд байдаг юм бэ гэдгийг би зүгээр тодруулж асууя.

2 жилийн өмнө хариулж байсан тэр хариулт чинь протокол дээр байгаа байх. Дараа дараагийн удаа илүү ил тод явуулна гэдэг ийм зүйлийг хэлээд л явуулж байсан юм шүү дээ. Тэгээд одоо тэр чинь бахь байдгаараа байна шүү дээ. Тэгээд 2 жилийн өмнө худлаа ярьсан юм уу гэж би асуух гэж байгаа юм.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Ц.Идэрбат гишүүнд баярлалаа. Асуултад нь хариулна байна. Х.Буянжаргал даргын 1 дүгээр микрофоныг өгнө үү.

**Х.Буянжаргал:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд Монголын Үйлдвэрчний холбооноос Монголын Үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбат Улсын Их Хурлаар томилогдон ажиллаж байсан.

Ингээд С.Эрдэнэбат дарга Улсын Их Хурлын гишүүн болсонтой холбогдуулаад албан ёсоор өөрөө Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлтээ Монголын Үйлдвэрчний холбоонд ирүүлсэн. Үүний дагуу бид Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ирцийг бүрдүүлэх, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь ажиллах боломжийг хангахын тулд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.2.2-т зааснаар даатгуулагчийн олонхын эрх ашгийг хамгаалсан байгууллагаас нэр дэвшүүлнэ гэсний дагуу бид Монголын Үйлдвэрчний холбооноос нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан.

Нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаад бид 5 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд албан ёсоор зар явуулсан. Мөн дотооддоо бас зар явуулсан.

Монголын Үйлдвэрчний холбоо өөрөө дүрэмтэй байгууллага. Энэ дүрэмд Монголын Үйлдвэрчний холбоо их хурлаараа дүрмээ баталдаг. Их хурлаар баталсан дүрэмд 20 дугаар зүйлийн 20.1.3-д хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан гурван талт Үндэсний хороо, зөвлөлүүдэд ажиллах Монголын Үйлдвэрчний холбооны төлөөллийг батлах, тэдгээрийн үйл ажиллагааг тайлагнах, тайланг хэлэлцэх гээд заасан байдаг.

Ийм учраас бид Монголын Үйлдвэрчний холбооны их хурал, Ерөнхий зөвлөлийн хурлын чөлөөт цагт эргүүлэгчид бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Тэгэхээр тэргүүлэгчдийн 2025 оны 01 сарын 09-ний өдрийн хурлаар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд нэр дэвшиж ирсэн. Одоо иргэдийн асуудлыг хэлэлцсэн.

Энд н.Гансүх Иргэний нисэхийн ерөнхий газрын инженер, сургагч, нисгэгч хүн нэр дэвшиж ирсэн. Дараа нь Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний үйлдвэрчний холбооны дарга н.Жавзандулам гэдэг эмэгтэй нэр дэвшиж ирсэн. Дараа нь Монголын Үйлдвэрчний холбооны ажлын албанаас Монголын Үйлдвэрчний холбооны Дэд ерөнхийлөгч Б.Рагчааг нэр дэвшүүлсэн.

Ингээд олонхын саналаар Б.Рагчаа дарга олонхын санал авч энэ Үндэсний зөвлөлд нэр дэвшихээр тогтоолоор батлагдсан байгаа юм.

Гэхдээ гишүүний асуусан асуултад тодотгож хариулахад Монголын Үйлдвэрчний холбооны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч Ерөнхий нарийн бичгийн дарга гэдэг гурван албан тушаал бол Монголын Үйлдвэрчний холбоог гадаад, дотоодод төлөөлөх ийм дүрмээр олгогдсон эрхтэй.

Тийм учраас ер нь Монголын Үйлдвэрчний холбооны бодлогыг Улсын Их Хурал, Засгийн газар бусад байгууллагуудтай уялдуулж асуудлыг нийт даатгуулагчдын, ер нь нийт гишүүдийн гаргаж байгаа бодлогыг үндэсний түвшинд гаргаж тавихад Монголын Үйлдвэрчний холбооны удирдах гурван субъектийг нэр дэвшүүлэх нь илүү зохимжтой гэж үздэг байгаа.

Тийм учраас Монголын Үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбатыг Их Хурлын гишүүн болсонтой холбогдуулаад Дэд ерөнхийлөгч Б.Рагчаа олонхын санал авч.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Баярлалаа. С.Эрдэнэбат гишүүн асуулт асууж, саналаа хэлнэ үү.

**С.Эрдэнэбат:** Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд миний бие ажиллаж байсны хувьд хэлэхэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг нь бид саяхан л баталж өгсөн. Шинэчилж.

Тэгээд яах вэ, сая процессын хувьд харахад Үндэсний зөвлөлд байгаа хүмүүсийн маань эрх, үүргийн асуудлыг маш тодорхой болгохгүй бол Үндэсний зөвлөлийн тайланг “зөвхөн Их Хуралд тайлагнана” гэдэг дүрэмтэй. Тэр дүрэм дотор нь “олон нийтэд тайлагнах” гэдэг зүйлийг нь тусгаж өгөөгүй. Тэгээд үүнийг саяхан би өөрөө санаачилж хоёр, гурван ч удаа Байнгын хороонд хандаж байж тавьж өгсөн байхгүй юу.

Тэгэхээр бид өөрсдөө энэ хүмүүсийн ажиллах юмыг нь бас давхар хийж өгөхгүй бол ингээд хязгаарлачихсан. Бараг олон нийтэд төлөөлөөд чи ярьчих юм бол нууц зөрчсөн, эрүүл мэндийн юутай холбоотой элдэв янзын мэдээллийг Үндэсний зөвлөлийг төлөөлж нэг гишүүн тайлагнахгүй гэж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ зүйл дээрээ Үндэсний зөвлөл дээр дэвшиж байгаа хүмүүстэй маш зөв яахгүй бол бид өөрсдөө хуулийг зөрчөөд даатгуулагчдадаа

тайлагнаж байх ёстой хүмүүс маань зөвхөн Их Хурал тайлагнавал болно гэдэг ийм журмаар яваад байдаг.

Тийм учраас саяхан энэ журмыг нь өөрчилсөн байгаа.

Тийм учраас энэ Үндэсний зөвлөл төлөөлж байгаа хүмүүс маань нэг байгууллага төлөөлнө гэхээсээ илүү нийт даатгуулагчдыг төлөөлж байгаа гэдэг зүйл дээрээ маш сайн ойлголт авахгүй бол төрийн байгууллагууд маань өөрсдөө сайд нь ч гэдэг юм уу базаад явчихдаг. Зөвхөн сайд л олон нийтэд гарч тэр мэдээллийг нь тавих ёстой мэтээр ойлгож байгаа нь их буруу явсан юм билээ.

Тийм учраас цаашдаа Үндэсний зөвлөл, энэ эрүүл мэнд, нийгмийн даатгал гэдэг бол массын асуудал. Яах вэ, тэр дарга, цэрэг нарын хувьд бол би ч өөрөө дарга нь байсны хувьд хэлэхэд өмнө нэг анхан шатын хорооноос ч гэдэг юм уу, нэг байгууллагаас төлөөлчихсэн хүмүүс маань нийт үүрэг, хариуцлага гэх талаасаа алдаатай юмнууд гаргаж байсан юм зөндөө байгаа.

Өөрөөр хэлбэл өөрийнхөө төлөөлж байгаа байгууллагынхаа үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэдэг нэг зарчим байгаа юм.

Өөрөөр хэлбэл тэр тухайн байгууллагын дээд удирдлагуудынх нь хүмүүс нь хариуцлагаа хүлээгээд. Намайг ч гэсэн тэгж л дэвшүүлж байсан л даа. Та Ерөнхийлөгч юм бол өөрөө хариуцлагаа хүлээгээд бүрэн төлөөлөөд тэнд ажилла. Тэгэхгүй бол нэг анхан шатын олон байгууллага дундаас нэгийг нь сонгуулчихаад тэгээд нөгөөдөх нь тэнд бүрэн хариуцлага хүлээж чадах уу, үгүй юу гэдэг асуудал талаас. Бид үүнийг зөвөөр ойлгох хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Тэгээд ер нь Үндэсний зөвлөлийн ажлыг илүү нээлттэй, ил тод байх шаардлага би байна уу гэж харж байгаа.

Тийм учраас энэ сонсголыг бол тэр 04 сарын 07-ны өдөр. Тэгээд бас нээлттэйгээр явуулах саналыг дэмжиж байна. Тогтоолын төслийг дэмжиж байна.

Тэгээд бүрэлдэхүүн нь яах юм? Энэ сонсгол зөвхөн даргалагчийг нь томилох билүү? Тийм ээ.

**Л.Энхнасан:** Баярлалаа. С.Эрдэнэбат гишүүнд. Бид сая журмаа батлахдаа таны гаргасан саналын дагуу хурлыг ил тод нээлттэй болгосон. Баярлалаа. Өмнө нь хаалттай байсан юм билээ. Тэгэхээр энэ журамд бас тусгагдсан байгаа.

Х.Булгантуяа гишүүн саналаа хэлж, асуултаа асууна уу.

**Х.Булгантуяа:** Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийг ер нь тэр чигээр нь шинэчлэх цаг бараг болсон юм биш үү гэж би зүгээр хувь хүний хувьд бодоод байгаа.

Одоо ийм гишүүдтэй байна гэнэ. Засгийн газрыг төлөөлөөд Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд. Даатгуулагчийг төлөөлөөд Монголын төмөр замчдын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга Б.Алтанхуяг, Т.Баясгалан Шинжлэх ухааны академийн харьяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, С.Эрдэнэбат одоо Улсын Их Хурлын гишүүн болсон. Монгол Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч.

Ажил олгогчийг төлөөлөөд хамгийн гайхалтай нь дандаа ашиг сонирхолтой зөрчилтэй хүмүүс байгаа юм уу гэж би бодоод байгаа юм. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж байгаа, ажилчдынхаа өмнөөс төлж байгаа хүмүүсийг төлөөлж сууж байгаа хүмүүс нь Ж.Гэрэлмаа Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн. Үйлчилгээ үзүүлэгч төлөөлж байгаа. Ш.Зоригоо Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч. Бас үйлчилгээ авагч. Н.Одонгуа Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Үндэсний төвийн эрдмийн зөвлөлийн хуулийн гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажиллаад байгаа юм биш үү.

Ажил олгогчдын гэдэг чинь уг нь Худалдаа аж үйлдвэрийн танхимаас томоохон групп, компаниудаас байх ёстой болохоос биш эрүүл мэндийн даатгалаас өөрснөө үйлчилгээ авч байгаа, мөнгө авч байгаа эрх ашгийн зөрчилтэй хүмүүс нь энд ажил олгогчдыг төлөөлж суух ёсгүй юм биш үү.

Магадгүй энэ хүмүүсийн гаргасан шийдвэрээс гэж байгаа юм биш. Ер нь энэ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн одоо бид нар чинь нийт шимтгэл төлөгчдийг төлөөлж удирдаж байгаа сангийн маань нөхцөл байдал хүнд байгаа.

Сая 2023 онд төрийн албан хаагчдын цалинг бид 23-аас 40 хэдэн хувьд нэмэхэд Эрүүл мэндийн даатгалын сан яг түүгээрээ орлого нь бас нэмэгдсэн. Тэгсэн мөртлөө бүр эсрэгээрээ бид алдагдалтай ажиллаж байна гэдэг ийм асуудлыг ярьж ж байгаа.

Хэрвээ магадгүй энэ сангуудын менежмент муу байх юм бол Нийгмийн бодлогын байнгын хороо холбогдох хуулиуд нь өөрчлөлт оруулаад шууд дуудаад асуугаад шинэчилдэг ийм нэг ийм зохицуулалтуудыг ер нь хийж өгөхгүй бол ингээд л яг шимтгэл төлөгч, нийгмийн иргэд, олон нийт маш ууртайгаар энэ шимтгэлийг төлж байгаа шүү дээ. Тэгсэн мөртлөө үйлчилгээгээ авч чадахгүй байна. Албан хүчээр бид нараас авч байна гээд. Тэгээд дараа нь бид нарын өмнөөс, нөгөө шимтгэл төлөгчдийн өмнөөс шийдвэр гаргаж байгаа хүмүүс

маань ийм зөрчилтэй байх юм бол яаж энэ сан яаж сайн удирдагдах вэ дээ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ чиг үүргийг нь та бүхэн маань ер нь нэг хараарай. Энэ чинь одоо тусламж ямар ямар тусламж үйлчилгээнүүдэд мөнгө өгөх вэ? Ямар даатгуулагчидтай ямархуу байдлаар гэрээ байгуулах вэ гээд ийм чиг үүрэг дээр ажиллах ёстой хүмүүс байгаад байгаа.

Дээрээс нь нэмээд энэ сангийн хөрөнгийн удирдлагыг хариуцах ёстой хүмүүс. Энэ дотор төсөв, санхүүгийн нарийн мэргэжлийн хүн Сангийн сайдаас өөр миний бодлоор бараг байхгүй байх.

Тэгэхээр энэ сангийн удирдлага яаж сайн явах вэ дээ. Тэгээд ийм зүйлүүд дээрээ нэг хэдүүлээ. Би одоо бас манай үйлдвэрчний эвлэл, том байгууллага, олон гишүүнчлэлтэй байгууллага юм чинь ийм нарийн мэргэжлийн хүмүүсээсээ та бүхэн оруулж ирвэл энэ сан маань илүү сайн удирдах.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Зөв зөв. Энэ асуудлыг бид журам ярьж байхдаа бас ярьж байсан.

Ялангуяа Ж.Чинбүрэн гишүүн зарим гишүүд ашиг сонирхолтой байна уу гээд бас асууж байсан. Энэ Зориггоо жишээлбэл Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч юм байна гээд.

Х.Булгантуяа гишүүний ярьж байгаа санал маш зөв. Бид нар үүнийг бас авч үзэх шаардлагатай юм байна. Тайланг 4 сард сонсоно. 4 сард сонсоно.

Тэгэхээр энэ үед бид Байнгын хороогоороо ер нь энэ гишүүдийн асуудлыг бас хамт нь авч үзэх шаардлагатай болбол нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой.

Хуралдаанд даргалагчийн зүгээс Д.Үүрийнтуяа гишүүнийг сонголт даргалагчаар томилох саналтай байна. Хэрвээ гишүүд өөр саналтай, эсвэл саналаа бас хэлж болно.

Тэгвэл гишүүд холбогдох асуудалтай холбоотой асуулт асууж, үгээ хэлж дууслаа. /алх цохив/

Тогтоолыг нь шууд уншчихъя.

Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол дар даргалагчийг томилох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121

дүгээр зүйлийн 120.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар товлосугай.

2.Нэр дэвшигчийн сонгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяаг томилсугай.

3.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, мэргэжил, арга зүйн техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Б.Баасандоржид тус тус даалгасугай.

Тогтоолыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Х.Болормаа, С.Эрдэнэбат. 100 хувиар дэмжсэн. Хуралдаанаар 100 хувийн саналаар дэмжигдлээ. Х.Болормаа гишүүн, С.Эрдэнэбат гишүүн дэмжсэнээр тооцно уу. 100 хувийн саналаар. Тийм.

Тогтоолын төсөл батлагдлаа.

---

### **Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл**

/Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай/

---

Хоёрдугаар асуудалд оръё.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэж заасны дагуу, 35.4-д Улсын Их Хурал энэ хуулийн 35.3-д заасан нэр дэвшигчийг сонгол хийж 6 жилийн хугацаагаар үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө гэж заасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурлаас томилсон Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн Ц.Сүхбаатарын 6 жилийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.1.2-т даатгуулагчийг төлөөлж Үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэж заасны дагуу Монголын үйлдвэрчний эвлэлээс Ж.Батзоригийг нэр дэвшүүлсэн Ж.Батзориг нэр дэвшигчийн мэдээлэл, хуулийн лавлагааг бас Та бүхэнд тараасан байгаа.

---

Гишүүдэд нэмж хэлэхэд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Л.Энх-Амгалангаас Ц.Сүхбаатарыг улируулан ажиллуулахаар санал ирсэн.

Мөн Монголын ахмадын холбооноос ахмадын холбооны гишүүн Ц.Товуусүрэн хөрөнгө даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэхээр хүсэлтийг бас Байнгын хороонд ирүүлсэн байгаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.1.2 даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэж заасны тулд бид хуулийн хүрээнд Үйлдвэрчний эвлэлийн саналыг хүлээн авч хэлэлцүүлэхээр байгаа.

Ажлын хэсгийг түрүүн танилцуулсан. Ажлын хэсэг хэвээрээ байгаа. Х.Буянжаргал Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, М.Нямдаваа Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр нийгмийн бодлогын газрын дарга оролцож байна.

Байнгын хорооны гишүүд Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Х.Булгантуяа гишүүнээр тасалъя.

А.Ариунзаяа гишүүн асуултаа асууж, саналаа хэлнэ үү.

**А.Ариунзаяа:** Сайн байцгаана уу?

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуулиар олгогдсон эрхийг бид хэрэгжүүлэхгүй, энэ боломжийг нь олгохгүй явсаар байгаад өнөөдрийн Нийгмийн даатгалын сангийн болоод Нийгмийн даатгалын ерөнхий энэ нөхцөл байдалд хүрсэн л дээ.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл уул шугамдаа шимтгэл хэдэн хувь байх вэ, тэтгэврийн нас хэд байх вэ, тэтгэврийн хэмжээ хэд байх вэ гэдгийг уул шугамдаа тогтоох үүрэгтэй. Гэтэл одоог хүртэл улс төрийн шийдвэрээр нөхөж энэ Үндэсний зөвлөл шийдвэрүүдийг гаргаж байсныг бишгүй дээ л бид мэднэ.

Ийм учраас Үндэсний зөвлөлийн гишүүд нь эрх мэдэл нь хуулиар олгогдсон үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа учраас энэ хэмжээгээрээ ч гэсэн энэ нэр дэвшилт болоод гишүүдэд нь нэг их айхтар ач холбогдол өгөхгүй явж ирсэн.

Цаашдаа мэргэжлийн байгууллагаар нь гэдэг юм уу, одоо энэ улс төрөөс хараат бус ажиллуулна гэдгийг бүхий л түвшинд уг нь ярьж хэлж байгаа. Гэсэн хэдий ч яг энэ Үндэсний зөвлөлдөө яг энэ нэр дэвшилтийг эргээд харах юм бол нөгөө л нэг хуучин уламжлалаараа яваад ирлээ.

Ц.Сүхбаатар гуай Ахмадын холбоог төлөөлж тухайн үедээ яг тэтгэвэр авч байгаа хүмүүсийн эрх ашгийг хамгаалах тал дээр нь Ахмадын холбооноос байвал яасан юм бэ гэдэг зөвшилцөлд хүрээд Үйлдвэрчний эвлэлийн 3 квотын нэг дээр нь Ахмадын холбоо орж ирж байсан түүхтэй.

Одоо орж ирж байгаа хүнийг хэрхэн яаж сонгон шалгаруулсан бэ? Өөрсдөө дотроо одоо энэ нээлттэй юу гэдэг юм сонсголыг явуулсан уу, үгүй юу гэдэг нь бидний эрх мэдлийн асуудал биш болчихоод байгаа байхгүй юу. Хуулиар Үйлдвэрчний эвлэлд хэнийг оруулж ирнэ вэ, тэрний сонсголыг нь явуулах нь ч өөрөө утгагүй асуудал болчихоод байгаа юм. Яагаад гэвэл оруулж ирж байгаа нэг л нэр дэвшигчийг бид ярих гээд байна шүү дээ. Өөр хэнтэй харьцуулах юм. Эсвэл яах вэ буцааж болох юм. Нэг удаа даа.

Тэгэхээр одоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр байгаа төлөөлөл дотор чинь багш нарын төлөөлөл байгаа шүү дээ. Тэгээд дахиад л нэг багшийн төлөөлөл оруулаад ирчхэж байгаа байхгүй юу. Тэгээд сайдынхаа саналыг нь аваад Ахмадын холбоотойгоо зөвшилцөөд Ахмадын холбооны саналыг авч болсонгүй юу. Уг нь одоо Ц.Товуусүрэн гуай бол миний нүдэнд маш сайн кандидат. Манай Нийгмийн даатгалын систем, одоо энэ бүх бодлогын хэмжээнд ч тэр маш сайн бэлтгэгдсэн үнэхээрийн мундаг хүн л дээ.

Тэгээд ер нь цаашдаа Нийгмийн даатгалын шинэчлэлийг явуулна, хуулийн төсөл өргөн барина гэж сайд мэдэгдсэн. Энэ дээрээ эргээд яг энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд орж байгаа хүмүүсийн төлөөллийг бас дахиад Х.Булгантуяа даргатай санал нэг байна. Шинэчлэх шаардлагатай. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийг яг утга агуулгаар нь ажиллуулж, улс төрийн шийдвэрүүдийг нөлөөлдөггүй байх энэ гарц гаргалгааг бид хуулиар зайлшгүй оруулах ёстой юм гэдгийг бас сануулж хэлье.

Ахмадын холбоотойгоо зөвшилцөж болсонгүй юу гэдэг асуултад хариулж өгөөч.

**Л.Энхнасан:** Х.Буянжаргал дарга хариулна уу. 1 дүгээр микрофон.

**Х.Буянжаргал:** А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Нийгмийн даатгалын тухай хуулийн 35.1.2-т даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх ашгийг хамгаалсан Үйлдвэрчний эвлэлээс 3 хүн байна гэсэн ийм хуулийн заалттай. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 сарын 19-ний 01 тоот тогтоолоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, журмыг шинэчлэн баталсан. Энэ дүрэм, журам хуулийн хүрээнд бид нэр дэвшигчдийг нээлттэй сонгон шалгаруулалтыг нь зарласан.

Эрдэнэсүрэн, Гансүх, Батзориг, Эрдэнэбаяр, Дагвадорж, Саранцацралт, тэгээд нэмэх нь ахмадын холбооны төлөөлөл Ц.Товуусүрэн гуайн асуудлыг бас бид хэлэлцсэн.

Ц.Товуусүрэн гуай одоогоор Үйлдвэрчний эвлэлийг төлөөлөх боломжгүй. Хуулиар Үйлдвэрчний эвлэлээс гэсэн байгаа.

Тэгэхээр Үйлдвэрчний эвлэлийг төлөөлөх боломжгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яг би өөрөө Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр юу гэж яригдсан бэ гэхээр тэтгэвэрт гарсан хүнийг даатгуулагчийг төлөөлөх үндэслэл байхгүй гэдэг асууд яригдаад одоо өнөөдөр ажиллаж байгаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан Баяраа гэж гишүүнийг жишээлбэл чөлөөлөх юм уу, яах юм гэдэг асуудал Үндэсний зөвлөл дээр яригдсан.

Ингээд Үйлдвэрчний эвлэлийг заавал төлөөлөх юм бол энэ хүн ямар албан тушаал дээр байх юм бэ гээд. Энэ хүн нь өөрөө албан ёсоор өргөдлөө өгөөд ингээд Монголын үйлдвэрчний холбоо хэдийгээр тэтгэвэрт гарсан ч гэсэн. Тэтгэвэрт гараад нэг жил болж байгаа юм. Тэгээд энэ хүнийг Ерөнхийлөгчийн зөвлөхөөр албан ёсоор томилж энэ Үйлдвэрчний эвлэлийг төлөөлөх ийм бүрэн эрхтэй болж ажиллаж байгаа.

Тэгэхээр Ц.Товуусүрэн гуайн хувьд 78 настай юм байна лээ. Тэгээд бас бидэнд албан ёсоор. Монголын үйлдвэрчний холбоо бүтэцтэй, улс орон даяар бүтэцтэй байгууллага. Тэгэхээр аль нэгэн үйлдвэрчний эвлэлд харьяалагддаггүй ийм хүн байлаа гэдгийг хэлье.

Тэгэхээр сая хэний Ж.Батзориг нэр дэвшигчийн тухай ярилаа. Ж.Батзориг нэр дэвшигч бол багш хүн биш. Багш нарын үйлдвэрчний холбоонд ажилладаг ч гэсэн түрүүн манай гишүүн өмнөх хэлэлцүүлэг дээр гишүүн хэлсэн. Заавал дарга нар байх ёстой юм уу. Жирийн одоо хүмүүс байх боломжгүй юм уу гэсэн.

Тэгэхээр энэ бол эдийн засагч хүн. Цэвэр мэргэжилтэн хүн гэж нэмж хариульъя. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тэгэхээр Ц.Товуусүрэн цуг нэр дэвшигчдийн юунд жагсаж орсон юм байна? Тийм ээ. Тэгж ойлгох уу? Тийм ээ.

**Х.Буянжаргал:** Монголын үйлдвэрчний холбооноос бид орж энэ улс орон даяар 5 телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан.

Энд албан ёсоор өөрөө материалаа огт ирүүлээгүй. Гэхдээ Ц.Сүхбаатар гуай би одоо ингээд хуулийн хугацаа дууссан учраас Байнгын хорооны хурал дээр та өөрөө орж танилцуулга хийхдээ Ахмадын холбооноос оруулж байгаа

нэр дэвшигчийг нь миний оронд дэмжиж өгөх боломж байна уу гээд бичгээ ирүүлсэн байгаа. Тэгээд бид хэлэлцсэн бас.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлж, асуултаа асууна уу.

**Б.Бат-Эрдэнэ:** Түрүүн ч нэлээн хэлчихсэн дээ. Тэгэхдээ энд ингэж байгаа юм. Даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэж байгаа байхгүй юу.

Тэгээд миний түрүүний хэлсэн үг ч гэсэн тэр л дээ. 6 жилийн хугацаагаар томилогдож байгаа шүү дээ. Одоо сонгогдож байгаа гэх юм уу, томилогдож байгаа гэх юм уу.

Тэгээд ийм удаан хугацаанд томилогдож ажиллаж байгаа хүмүүс яагаад энэ 6 жилийн хугацаанд та нар даатгуулагчийн эрх ашгаа хамгаалахгүй байгаа юм. Хэрвээ хамгаалж байсан бол өнөөдөр ийм асуудал үүсэхгүй шүү дээ. Та нар юу хийдэг юм, юу хийх гэж очдог юм тэнд.

Би түрүүн энэ Байнгын хороо эхлэхээс өмнө С.Эрдэнэбат гишүүнээс асуусан юм. Хуулийн хариулт л байсан л даа. Зөв л дөө. Би бол танай байгууллагыг эсэргүүцээгүй. Хуульд заасан учраас явах ёстой. Гэхдээ Х.Булгантуяа гишүүний саналтай санал нэг байгаа.

Бид өнөөдөр энд ингээд л томилгоо яриад л байдаг. 6 жилээр. Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил шүү дээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хугацаа 6 жил байгаа. 6 жил гэдэг бас нэг талдаа урт хугацаа байхгүй юу.

Яагаад 6 жилээр оруулж өгч байна гэхээр үр дүнтэй байгаасай, тасралтгүй үйл ажиллагаа яваасай гэсэндээ л байхгүй юу. Би бол тэгж ойлгож байгаа. Тэгээд та нарыг даатгуулагчийг төлөөлөөд даатгуулагчийн олонхын эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалаач ээ гээд Үйлдвэрчний эвлэлээс 3 хүн оруулаад байдаг. Дүрэм журам юм уу, хууль руу чихээд суугаад баймааргүй байгаа байхгүй юу. Үгүй ээ тэгээд асуудалтай байсан юм бол асуудлыг нь оруулж ирээд л Байнгын хороон дээр асуудал хэлэлцүүлээд л Улсын Их Хурлаар оруулаад л хуулийг өөрчилж болно шүү дээ. Алдаатай байгаа бол засах ёстой шүү дээ. Тийм биз дээ.

Тэгээд Монгол Улсын хөгжихгүй байгаа үндсэн суурь шалтгаануудын нэг нь ч гэсэн ер нь бол энэ. Бид нар нэг л их томилгоо ярьдаг. Орж ирээд л нэг л их албан ёсны хариулт өгдөг. Нөгөө хүмүүс нь 6 жил дархлагдчихсан. Даатгуулагчийнх нь маш олон асуудлууд хохироод байхад нэг талдаа хамгаалсан, эрх ашгийнх нь төлөө зогссон үйлдэл гардаггүй. Магадгүй гарч байгаа нь ахицтай явдаггүй. Эсвэл бид нар цөөддөг гэдэг юм ярьдаг. Эсвэл

хууль, дүрэм журам руу чихдэг ийм байдал дээр л байгаа байхгүй юу. Тэгээд харамсалтай байна.

Би бол үүнийг харамсалтай байна гэж хэлнэ. Өнгөрсөн 6 жилийн хугацаанд тэр хүмүүс ажиллаад өнөөдөр дараагийн хүмүүс нь орж ирэх гэж байх шиг байна. Та өнөөдөр өөрөө бас ажиллаж байгаа юм байна.

Яагаад Нийгмийн даатгалын сан дээр ийм асуудлууд үүсээд байна? Яагаад энэ нийгмийн даатгалтай холбоотой асуудлууд ахиц гарахгүй байгаа юм? Өнөөдөр хуулийн Нийгмийн даатгалын багц хуультай холбоотой асуудлууд яригдаж байна лээ.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Х.Буянжаргал дарга хариулна. 1 дүгээр микрофон.

**Х.Буянжаргал:** Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульъя.

Тэгэхээр хуульд даатгуулагчийг төлөөлсөн, олонхын эрх ашгийг хамгаалсан Үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэсэн байгаа.

Тэгэхээр бид зөвхөн Үйлдвэрчний эвлэлээр хязгаарлагддаггүй юм. Бидний Үйлдвэрчний эвлэлийн дүрэм гишүүддээ болоод нийгэмд үйлчлэх асуудал байгаа.

Тэгэхээр 1.5 сая сайн дурын болоод албан журмын даатгуулагчдаа нэмээд үзэх юм бол 1.5 сая орчим даатгуулагчид байгаа.

Тэгэхээр энэ даатгуулагчдын асуудлыг бид Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн үндэсний хороо, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн улсын хэлэлцээрт тусгаж бас олонх асуудлуудыг шийддэг байгаа.

Тэгэхээр Нийгмийн даатгалын. Одоо Б.Бат-Эрдэнэ гишүүнтэй би санал нэг байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл өнөөдөр Нийгмийн даатгалын шинэ хууль гарсантай холбогдуулаад маш их няхуур алдаагүй шийдвэр гаргах боломж бас бүрдсэн гэдгийг Их Хурлын гишүүдэд бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Хуульд өөрчлөлт орсон, мэргэжлийн хороотой болсон, хяналтын зөвлөлтэй болсон. Энэ мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт саналыг үндэслэчхээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл шийдвэрээ гаргадаг болсон.

Тэгэхээр өмнө нь гаргаж байсан алдаатай, улс төржсөн, олон шалтгаануудыг түрүүн А.Ариунзаяа гишүүн хэлсэн.

Тэгэхээр ийм шийдвэр гаргуулахгүй байхын төлөө Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл шинэ бүрэлдэхүүнээрээ бид маш эрч хүчтэй ажиллаж эхэлж байгаа. Бид одоо Улсын Их Хурлын Байнгын хороон дээр Нийгмийн даатгалын

үндэсний зөвлөл тайлангаа хамгаалахад манай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга болоод гишүүд тодорхой мэдээлэл асуудлаа бид ярих болно гэдгийг хэлье.

Тэгээд манай нэр дэвшигчийг Та бүхэн хуулийн хүрээнд нэр дэвшүүлсэн. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр нээлттэй сонгон шалгаруулалтаар бид оруулаад ирсэн нэр дэвшигч Ж.Батзоригийг Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тодруулах уу? Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулах.

**Б.Бат-Эрдэнэ:** Санал нэг байгаад баяртай байна. Тийм. Гэхдээ би ойлгосонгүй.

Үйлдвэрчний эвлэлээ төлөөлж яриад байгаа юм уу, Үндэсний зөвлөлд орж байгаа гишүүнийгээ хамгаалж яриад байгаа юм уу, эсвэл 1.5 сая даатгал төлж байгаа иргэнийхээ асуудлыг яриад байгаа юм уу. Би тэнэг байж магадгүй л дээ. Гэхдээ энэ Үндэсний зөвлөл чинь эрх, үүрэгтэй шүү дээ. Хариуцлагатай, эрх, үүрэгтэй. Бид Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн журам дүрэм, бүгдийг нь баталж өгсөн. Сая.

Тэгээд энэ даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг л хамгаалах энэ ажлыг л хийх ёстой шүү дээ. Тэгээд Үйлдвэрчний эвлэлийн дүрэм журам энэ ямар хамаатай юм. Үйлдвэрчний эвлэлийн дүрэм журамд хамаарсан байдлаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа хамааралтайгаар явагддаг юм уу?

**Л.Энхнасан:** Х.Буянжаргал дарга хариулна. 1 дүгээр микрофон.

**Х.Буянжаргал:** Би бас буруу ойлгуулчихсан юм болов уу даа.

Тэгэхээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчийгээ бид сонгон шалгаруулах асуудал бол Үйлдвэрчний эвлэлийн дүрэм журмын хүрээндээ бид даатгуулагчийн олонхыг төлөөлсөн Үйлдвэрчний эвлэлээс гэсэн учраас Үйлдвэрчний эвлэлийн дүрэм журмын хүрээнд бид ийм асуудлаа хийсэн гэдгийг хэлж байгаа юм.

Нийт даатгуулагчдын хувьд манай Монголын үйлдвэрчний холбооноос нэр дэвшсэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд бид ингэж ажиллана л гэсэн ийм л агуулгаар хэлсэн юм.

**Л.Энхнасан:** Х.Буянжаргал дарга тодруулаад хариултаа өгчих үү? Яг ойлгомжтой.

**Х.Буянжаргал:** Нийт сайн дурын болоод албан журмын даатгал төлөгч 1.5 сая орчим иргэдийн эрх ашгийг хамгаална л гэж байгаа юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** С.Эрдэнэбат гишүүн асуултаа асууж, саналаа хэлнэ үү.

**С.Эрдэнэбат:** Нийгмийн даатгалын асуудал дээр бид өмнө нь нэлээн л олон зүйл болж байсан. Би ч гэсэн өөрөө түрүүн. Манай Б.Бат-Эрдэнэ гишүүн ч гэсэн асууж байх шиг. Юу хийсэн юм гэж.

Капитал банкныг дампууруулах Нийгмийн даатгалын дампуурлын эхлэл энэ Үндэсний зөвлөлийн томилгооноос эхтэй байсан юм шүү. 13 жилийн өмнө.

Ганцаараа яахаараа Үйлдвэрчний эвлэлийнхэн байгаад байдаг юм. Өөр олон хүн томил гэж байгаад тамга хармаалсан хэдэн хүмүүсийг оруулж ирсэн. Тэр хүмүүс нь яасан гэсэн. Ашиг сонирхлын зөрчилтэй банканд тухайн үеийнхээ тэр сайд дарга нарыгаа дагаад гараа өргөөд, эрсдэлтэй өөрийн нөөцийн хөрөнгө чадавх багатай ийм банкнууд тавиад. Тэрнээс эхлэлтэй юм билээ.

Тийм учраас энэ Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд томилох дээр бол чухал ач холбогдол өгч байгааг манай Үйлдвэрчний эвлэлийнхэн ч гэсэн зөвөөр ойлгоорой гэдгийг бас хэлмээр байна.

Нөгөө талаараа түрүүн А.Ариунзаяа дарга хэллээ. Бие даасан чадавх гэдэг зүйл дээрээ жоохон анхаараарай. Тэгээд л үе үеийн даргалж байгаа сайд дарга нарыгаа гэдэг юм уу, ийм зүйл рүү хэт дагахаараа л буруутгах гээд байдаг. Тэгэхдээ яах вэ би одоогийн байгаа хүмүүсийг бас тэгж хэлж байгаа юм биш. Юм хийх болов уу.

Нийгмийн даатгалын шинэчлэл дээр голчлон ажиллаж байсны хувьд тэр тэтгэврийг өвлүүлэх. 30 жил төлчхөөд нэг ч төгрөгийн, оршуулгын зардлаас өөр юм авч чаддаггүй байсныг л бид нар хийж өгсөн шүү дээ.

Тийм учраас Үндэсний зөвлөлийн ил тод байдлыг би түрүүн бас хэлсэн. Нээлттэй хуралдана. Нээлттэй хуралдана гэдгийг харин бас хурлаа хийснийхээ дараа нэг хэдэн хэвлэл мэдээллийг цуглуулж байгаад ингэлээ ингэлээ гэдгийг бас хэлэхгүй шүү. Одоо Байнгын хороо шууд нээлттэй явж байгаа шүү дээ. Үүн шиг зарим хурлуудыг хийж байх ёстой.

700 тэрбум төгрөгийг банканд хадгална гэдэг шийдвэр гаргасан байна лээ. Тэрийгээ мэдээлж байгаа нь сайн. Магадгүй түүхэндээ анх удаагаа бид нарын баталж өгсөн журмаар бид нар ийм ийм ийм шийдвэрийг ингэж гаргалаа, үүнийг банканд хийхээр боллоо гэдгийг тавьсан. Гэхдээ одоо үүнийг чинь дагаад хэчнээн банк, хэчнээн нөхдүүд лобби хийж гүйлдэх бол доо. Үүнээсээ та бүгд маань би анхааруулж хэлье.

Дараагийн тэр сонсгол тайлан юман дээр мэдээлэл авсан. Дээрээс нь тэр Б.Бат-Эрдэнэ гишүүний асуугаад байгаа зүйл дээр тодруулаад хэдүүлээ баримттай бас ярих хэрэгтэй.

Энэ өнгөрсөн хугацаанд Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хэн яаж удирдсан гээд би протоколыг нь хэн ямар санал өгсөн юм, би нэхсэн байгаа шүү. Одоо хүртэл надад ирэхгүй байгаа. Хэрвээ өгөхгүй бол би үүнийг чинь Ёс зүйн хороонд өгөөд Их Хурлын гишүүдийн өгсөн асуулт хариултыг өгөөгүй тохиолдолд хариуцлага тооцох асуудлыг яриулна.

Тийм учраас энэ тал дээр одоо харин тэр Капитал банкиг дампуурч байхад хамгийн түрүүнд Үйлдвэрчний эвлэлийнхэн л гүйж очиж байсан. Тэр мөнгөө нэхэж талбай дээр хэн сууж байсан. Үйлдвэрчний эвлэлийнхэн л сууж байсан.

Тийм учраас энэ тал дээр энэ байгууллагын хувьд нэг хоёр хүний асуудлаас болоод бүгдэд нь та нар юу хийсэн юм гэдэг дээр эргээд энэ тайлан мэдээллээ гишүүддээ сайн өгөөрэй. Юу юу хийж байсан гэдгээр.

Тийм учраас сонсголын хувьд хэлэхэд Ц.Сүхбаатар гуайг хэлэхэд өөрөө Ахмадын холбооны дарга байж өөрөө нэг хүн дэвшүүлээд тэгээд сайдаар болохоороо.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Х.Буянжаргал дарга асуултад хариулна уу. 1 дүгээр микрофон.

**Х.Буянжаргал:** С.Эрдэнэбат гишүүн тодорхой зүйлүүдийг ярьж байна л даа.

Тэгэхээр Монголын үйлдвэрчний холбооноос өмнөх хуулийн хэрэгжилтийн үед орж бас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд ажиллаж байсан хүмүүс эрх мэдэл нь дутаад гэх юм уу, эсвэл ёстой гишүүний хэлдгээр бие даасан гишүүнийхээ, Улсын Их Хурлаар томилогдсон гишүүнийхээ бие даасан байдлыг хадгалж чадахгүй байдлаас болж зарим зүйлүүдэд алдаа гаргасан байхыг үгүйсгэхгүй.

Энэ бол нийт даатгуулагчдын хөрөнгө. Өнөөдөр Капитал банк, Чингис хаан банкнаас 102.4 тэрбум төгрөг төлөгдөөгүй. Эрх хүлээн авагчаас төлөгдөөгүй Нийгмийн даатгалын сан дээр ийм нөхцөл байдалтай байгаа.

Энэ асуудал дээр Монголын үйлдвэрчний холбооны ерөнхий зөвлөлийн хурлаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүддээ бас энэ өр авлагыг барагдуулах талаар нэлээн чиглэл өгсөн. Энэ талаар бид тодорхой зүйлүүдийг тавьж энэ асуудлаар нээлттэй, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлыг хэвлэл мэдээлэл бусад хууль хүчний байгууллагуудыг оролцуулж байгаад нээлттэй хийе гэдэг саналыг миний бие оруулсан байгаа. Энэ бэлтгэл ажлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба хангаад явж байгаа гэдгийг бас хэлье.

Тэр 700 тэрбум төгрөг системийн нөлөө бүхий 5 банканд байршуулахаар 02 сарын 24-нд шийдвэр гарсан боловч Монголбанкны бодлогын хүү өөрчлөгдсөнтэй холбогдуулаад сая яг өнөөдрийн байдлаар биднээс санал авсан. 12.2 хувь. Монгол банкны бодлогын хувиас дээш байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хэлэлцэхээр болж байгаа.

Тийм учраас даатгуулагчдын хөрөнгийг үр ашигтай банканд байршуулж, мөнгөн хөрөнгийг өсгөх талаар тодорхой зүйлүүдээ хийнэ.

Манай нэр дэвшигчийн хувьд тодорхой зүйлүүд дээр хэрвээ Байнгын хороо, Их Хурал дэмжээд ажиллах юм бид бүрэн бүрэлдэхүүнээрээ болоод энэ асуудалд онцгой анхаарч ажиллах болно гэж хариулъя. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа.

Тэгэхээр хурлыг нээлттэй үзэж болохоор хуралдаж байгаа гэж ойлгож болох уу? Ер нь тэгж хуралдаж байсан уу? Хуралдсан уу? Журам шинэчилж батлагдсаны дараа та хэд нэг, хоёр хуралдсан шүү дээ.

**Х.Буянжаргал:** Тэгэхээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурал бүрэн хэмжээнд нээлттэй явж чадахгүй байгаа. Хуралдаад дараа нь талууд мэдээллээ өгөх хэмжээнд л байгаа даа.

**Л.Энхнасан:** Х.Булгантуяа гишүүн асуултаа асууж, саналаа хэлнэ үү.

**Х.Булгантуяа:** Би ингэж бодоод байгаа юм. Яах вэ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл бас 9 гишүүнтэй. Засгийн газрыг төлөөлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүйн сайд. Даатгуулагчийг төлөөлж ганцхан Үйлдвэрчний эвлэлээс орох байгаа. Тэгэхдээ даатгуулагч гэдэг нь зөвхөн өнөөдрийн шимтгэл төлөгч бас биш байхгүй юу. Тэр чинь өнөөдөр Ахмадын холбоо бол шимтгэлээ төлчхөөд тэтгэврээ авч байгаа 500 мянган хүмүүсийг төлөөлж байгаа. Уг нь бол. Бас нөгөө талаасаа.

Тэгэхээр би Үйлдвэрчний эвлэлийг бас энэ дээр 500 мянган хүний эрх ашгийг төлөөлж орж байгаа байгууллагыг тэтгэврийн насны хүн гэж. Энэ бол орон тооны ажил угаасаа биш. Та мэдэж байгаа. Бид суусан хурлынхаа хэмжээгээр нэг хэдэн төгрөгийн урамшуулал авдаг. Багахан төгрөгийн. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр нэгэнт тэр хүмүүс төлсөн нь үнэн. Зарим нь 20 жил. Зарим нь 30, 40 жил төлсөн нь үнэн.

Тийм учраас уг нь ахмадын төлөөлөл байх нь их зөв зүйтэй байгаа юм. Энэ хүмүүсийг өнөөдөр яг тэтгэврээ авч байгаа хүмүүсийн хувьд. Яагаад гэвэл эндээс тэтгэврийн хэмжээнээс авхуулаад “итгэлцүүр” гээд олон шийдвэрүүд гардаг учраас “шимтгэл төлөгч” залуучууд бид аягүй бол тэтгэврийн асуудлыг

харахгүй байж магадгүй гэж үзэж ахмадын төлөөлөл байх нь би бол зүйтэй гэж бодож байгаа.

Сая Ахмадын холбооны дарга Ц.Сүхбаатар гишүүн бол өөрөө энэ Нийгмийн даатгалын байгууллагыг бас удирдаж ажиллаж байсан хүний хувьд сая ялангуяа энэ олон тооцоол хийхэд маш нарийн сайн ажиллаж байсан ийм хариуцлагатай гишүүн байсан.

Тэгэхээр үүнийгээ бид бодох ёстой. Ер нь энэ Үндэсний Зөвлөлд заавал залуу хүний л төлөөлөл байх ёстой. Тэтгэвэрт гарсан хүн байх ёсгүй гэдэг тийм юм бас байхгүй шүү дээ. Энэ дээр ерөөсөө нас заагаагүй.

Дээрээс нь нэмээд Улсын Их Хурлын батлагдсан энэ оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлж байгаа Ахмад настны хуулиар төрийн болон бусад бүх байгууллагууд 10 хүн тутамдаа нэг ахмад настанг авч ажиллуулах ёстой. Хэрвээ тэгэхгүй бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлөхөөр хуульчилсан байгаа.

Тэгэхээр энэ бол зүгээр эрх ашгийг хангаж тэнд шийдвэр гаргах байгууллага байх ёстой болохоос биш энэ бол аль нэг байгууллагын төлөөлөл ганцхан ерөөсөө биш ээ гэж би бас хараад байгаа юм.

Тэгэхээр одоо манай хуулиар ийм болчхоод байгаа байхгүй юу. Шимтгэл төлөгч бүх хүмүүсийг, Монголын бүх шимтгэл төлөгчдийг ганцхан Үйлдвэрчний эвлэлд төлөөлнө. Тийм байгаа биз. Яг тэгж уншина. 3-хан төлөөлөгчтэй байна, төлөөлөлтэй байна. Тэр нь зөвхөн Үйлдвэрчний эвлэлээс байна гэж болчхоод байгаа юм.

Тэгээд би бас манай Үйлдвэрчний эвлэлийг Та бүхэн бас 500 мянган тэтгэвэр авагчдынхаа төлөөллийг өмнө нь ойлголцоод төлөөллийг нь хангаад байж байсан юм чинь ахиад цаана нь 2 хүн байгаа шүү дээ. 9 хүн дотроос. Тийм ээ.

Тэгэхээр бас байж болох л хувилбар юм биш үү. Заавал ингэж хатуурхах шаардлага байгаа юм уу. Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл 3 байгаагүйгээс болоод энэ сангийн удирдлага муудчихсан ч бас биш л дээ. Тэгж бид бас арай ярьж болохгүй.

**Л.Энхнасан:** Х.Буянжаргал дарга хариулна уу. 1 дүгээр микрофон.

**Х.Буянжаргал:** Тэгэхээр Нийгмийн бодлогын байнгын хорооноос Монголын үйлдвэрчний холбоонд албан тоот ирсэн. Энд Ц.Сүхбаатар гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулаад нэр дэвшүүлээч ээ. Хуулийн хүрээнд нэр дэвшүүлээч ээ гэсэн.

Бид Нийгмийн даатгалын тухай хуулийн 35.1.2-т заасны дагуу нэр дэвшүүлэх ажиллагааг улс даяар бид зарласан. Нээлттэй зарласан.

Энд албан ёсоор ахмадуудын төлөөллөөс нэр дэвшиж ямар нэгэн материал ирүүлээгүй. Зөвхөн Ц.Сүхбаатар гишүүн надад Та би бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаа учраас манай Ахмадын холбооноос нэр дэвшиж байгаа Ц.Товуусүрэн гуайг дэмжиж өгөхийг хүсэж байна. Хууль тогтоогч байсан гээд ярьсан.

Ахмадын төлөөлөл өнөөдөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд байна уу гэвэл байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл мэргэжлийн хороотой болсон. Хяналтын зөвлөлтэй болсон. Мэргэжлийн хороо хяналтын зөвлөлд Нийгмийн даатгалын системийн байгууллагуудыг удирдаж байсан олон ахмад настнууд яг энэ ажлын албанд ажиллаж байгаа гэдгийг бас Та бүхэнд онцолж хэлье. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тодруулж асуух уу? Болсон уу? Х.Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Олон нийтийн хяналтын зөвлөл уг нь арай нарийн мэргэжлийн байгууллага л даа. Яг Үндэсний зөвлөлтэй адилхан биш.

Эндээс тэтгэврийн хэмжээ, дээрээс нь нэмээд арга аргачлал, олон журмууд гаргадаг байгууллага биш. Шинэ хуулийн дагуу ийм зөвлөлтэй болсон нь сайшаалтай. Энэ сангийнхаа удирдлага дээр илүү их мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх чиг үүрэгтэй. Тийм ээ. Бид хуулиараа тэгж баталсан.

Энэ дээр илүү их санхүүгийн шинжээчид ийм хүмүүс байхгүй бол яг үнэнийг хэлэхэд манай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр энэ хэдэн зуун тэрбум төгрөгийг хаана яаж байршуулах вэ гэдэг ийм нарийн санхүүгийн тооцоолол гаргадаг хүмүүс үнэнийг хэлэхэд байхгүй.

Ажил олгогчдын төлөөллөөс ч байхгүй. Манай юунуудын төлөөллөөс ч байхгүй. Бид нарын хувьд энэ бол бүр ингээд нөгөө “хөрөнгө оруулалтын менежер” гэдэг нарийн мэргэжил байхгүй юу. Үндэсний зөвлөл бол ондоо. Шимтгэл төлж байгаа, эсвэл төлсөн хүмүүсийн төлөөлөл бид нарын шимтгэлийг ингээч ээ гэдэг шийдвэр гаргах гэж байгаа байгууллага.

**Л.Энхнасан:** Ойлголоо. Гишүүд асуулт асууж, саналаа хэлж дууслаа.

Хуралдаан даргалагчийн зүгээс Ц.Идэрбат гишүүнийг сонголт даргалагчаар томилох саналтай байна. Гишүүд өөр саналтай саналаа бас хэлж болно.

Асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар товлосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатыг томилсугай.

3.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Л.Энхнасан/, мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Баасандорж/-т тус тус даалгасугай.

Тогтоолыг энэ нэр томъёоллоор баталъя. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Тогтоол 91.7 хувиар батлагдлаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлууд дууссан. Гишүүд идэвхтэй оролцсонд баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 05 минут үргэлжилж, 11 цаг 30 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**ЦАЛТАН-ОД**